

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2019 оны жилийн эцэс/

2020 оны 1 дүгээр сар 14

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.

Монгол Улсын хууль, Улсын Их Хурал болон УИХ-ын байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, албан даалгавраар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гарсан шийдвэр заалтыг хяналтад авч, яамны нэгжүүдийн 2019 оны жилийн эцсийн байдлаар ирүүлсэн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Уул уурхайн хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/122 дугаар тушаалаар баталсан, “Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ыг тус тус удирдлага болгов.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн цахим хуудсанд байршуулсан шийдвэр, заалтыг 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар тасалбар болгон Геологи, эрдэс баялгийн, Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн түүний нөөцийн, Уул уурхайн, Хүнд үйлдвэрийн, Нийтлэг асуудал гэсэн ангилал тус бүрээр хэрэгжилтийг гаргуулж үнэлгээг хийв.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.

2019 оны жилийн эцсийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn цахим системд байршуулсан нийт 109 шийдвэрийн 157 заалтын хэрэгжилтийг **90,6** хувийн биелэлттэй дүгнэв. Үүнд:

- Геологи, эрдэс баялгийн бодлогын хүрээнд 15 шийдвэрийн 17 заалтын хэрэгжилт 89,6%,
- Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлогын 21 шийдвэрийн 34 заалтын хэрэгжилт 94,7%,
- Уул уурхайн бодлогын 41 шийдвэрийн 61 заалтын хэрэгжилт 92,1%,
- Хүнд үйлдвэрийн бодлогын 10 шийдвэрийн 11 заалтын хэрэгжилт 81,0%,
- Нийтлэг асуудлын 22 шийдвэрийн 34 заалтын хэрэгжилт 96,7%-ийн тус тус биелэлттэй, 14 заалтын биелэлтэд үнэлгээ өгөөгүй. Үнэлгээгүй эдгээр зүйл заалт хүчингүй болсон, хэрэгжилт тооцох хугацаа болоогүй байна. Нэгдүгээр хүснэгт.

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ
/2019 оны жилийн эцэс/

Нэгдүгээр хүснэгт

Салбар, чиглэлийн нэр	Хяналтанд авсан тоо		Хэрэгжилтийн явц /хувиар/					Үнэлгээ /%/
	шийдвэр	зүйл заалт	100%	70%	30%	0%	Үнэлээ гүй	
НЭГ. ГЕОЛОГИ, ЭРДЭС БАЯЛГИЙН БОДЛОГО								
Засгийн газрын тогтоол	10	12	11		1			94.2
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	5	5		2	2		1	85.0
ГЭББ-ын дүн	15	17	11	2	3		1	89.6
ХОЁР. ГАЗРЫН ТОС, ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН ТҮҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААРХ БОДЛОГО								
Монгол Улсын хууль	1	3	2	1				90.0
УИХ-ын тогтоол	1	1	1					100.0
ҮАБЗ-ийн зөвлөмж, тэмдэглэл	1	1	1					100.0
Засгийн газрын тогтоол	5	11	10	1				97.3
Ерөнхий сайдын захирамж	1	1	1					100.0
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	12	17	13	4				93.0
ГТГТББТНТБ-ын дүн	21	34	28	6				94.7
ГУРАВ. УУЛ УУРХАЙН БОДЛОГО								
Монгол Улсын хууль	3	3	3					100.0
Их хурлын тогтоол	1	2	1	1				85.0
УИХ-ын Байнгын хорооны тогтоол	3	4	2	2				85.0
ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл	1	1	1					100.0
Засгийн газрын тогтоол	18	30	20	7			3	92.2
Ерөнхий сайдын захирамж	3	3	1				2	100.0
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	12	18	11	3	3		1	82.4
ЗГ-ын албан даалгавар								
УУБ-ын дүн	41	61	39	13	3		6	92.1
ДӨРӨВ. ХҮНД ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГО								
Монгол Улсын хууль	1	1					1	
УИХ-ын тогтоол	1	1	1					100
Засгийн газрын тогтоол	2	3		3				70
Ерөнхий сайдын захирамж	2	2	2					100
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	4	4	2	1	1			75
ХҮБ-ын дүн	10	11	5	4	1		1	81
ТАВ. НИЙТЛЭГ АСУУДАЛ								
Монгол Улсын хууль	1	1		1				70.0
УИХ-ын тогтоол	1	1	1					100.0
Ерөнхийлөгчийн зарлиг	1	2	2					100.0
Засгийн газрын тогтоол	11	14	12	2				95.7
Ерөнхий сайдын захирамж	1	1	1					100.0
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	5	8	8					100.0
ЗГ-ын албан даалгавар	2	7	1				6	100.0
Нийтлэг асуудлын дүн	22	34	25	3			6	96.7
Эрх зүйн баримт бичгийн дүн	109	157	108	28	7		14	90.6

Хэрэгжилт гаргаж дүгнэсэн 157 заалтын 108 заалт буюу 68,7% бүрэн биелсэн, 28 заалт буюу 17,8% хэрэгжих шатанд буюу 70 хувийн биелэлттэй, 7 заалт буюу 4,4% нь хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувийн тус тус хэрэгжилттэй, үнэлгээ өгөөгүй 14 заалт 8,9%-ийг эзэлж байна. Хоёрдугаар хүснэгт.

ҮНЭЛГЭЭ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙВЭРИЙН ТӨРЛӨӨР
/2019 оны жилийн эцэс/

Хоёрдугаар хүснэгт

		Бүгд	МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөн хийлэг чийн зарлиг	ҮАБЗ-ийн зөвлөмж, тэм дэглэл	ЗГ-ын тогтоол	ЕС-ын захирамж	ЗГ-ын хурал дааны тэмдэг лэл	Засгийн газрын албан даалгавар
Хяналтанд авагдсан шийдвэрийн тоо		109	6	4	3	1	2	46	7	38	2
Заалтын тоо		157	8	5	4	2	2	70	7	52	7
Үүнээс	Биелсэн 100%	108 <i>/68,7%/</i>	5	4	2	2	2	53	5	34	1
	Хэрэгжих шатанд 70.0%	28 <i>/17,8%/</i>	2	1	2			13		10	
	Хэрэгжилт хангалтгүй 30.0%	7 <i>/4,4%/</i>						1		6	
	Хэрэгжээгүй 0%	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Дүгнэгдээгүй	14 <i>/8,9%/</i>	1					3	2	2	6
	Үнэлгээ	90,6	91,4	94,0	85,0	100	100	93,1	100	85,6	100

Эрх зүйн актын хэрэгжилтийг төрлөөр нь авч үзвэл:

- Монгол Улсын 6 хуулийн 8 заалтаас бүрэн хэрэгжсэн 5, хэрэгжих шатанд 2, хэрэгжилтийн дундаж 91,4%-тай,
- Улсын Их Хурлын 4 тогтоолын 5 заалтаас бүрэн хэрэгжсэн 4, хэрэгжих шатанд 1, хэрэгжилтийн дундаж 94,0%-тай,
- УИХ-ын Байнгын хорооны 3 тогтоолын 4 заалтаас бүрэн хэрэгжсэн 2, хэрэгжих шатанд 2, хэрэгжилтийн дундаж 85,0%-тай,
- Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 2 заалт бүрэн хэрэгжсэн 100%-тай,
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2 шийдвэрийн 2 заалт бүрэн хэрэгжсэн, хэрэгжилтийн дундаж 100%-тай,
- Засгийн газрын 46 тогтоолын 70 заалтаас бүрэн хэрэгжсэн 53, хэрэгжих шатанд 13, хэрэгжилт удаашралтай 1, хэрэгжилтийн дундаж 93,1%-тай
- Ерөнхий сайдын 7 захирамжийн 7 заалтаас бүрэн хэрэгжсэн 5, үнэлээгүй 2, хэрэгжилтийн дундаж 100%-тай,
- Засгийн газрын хуралдааны 38 тэмдэглэлийн 52 заалтаас бүрэн хэрэгжсэн 34, хэрэгжих шатанд 10, хэрэгжилтийн дундаж 85,6%-тай,
- Засгийн газрын 2 албан даалгаврын 7 заалтаас 1 заалт бүрэн хэрэгжсэн, хэрэгжилт тооцох хугацаа болоогүй 6 заалт, хэрэгжилт 100%-ийн тус тус биелэлттэй байна.

Дөрөв. Дүгнэлт.

1. ЗГХЭГ нь 2019 оны жилийн эцсийн байдлаар харьцангуй цөөн буюу 109 шийдвэрийн 157 заалтыг хяналтанд оруулсан нь өмнөх жилүүд */2016 оны жилийн эцэст 289 шийдвэрийн 416 заалт, 2017 оны жилийн эцэст 156 шийдвэрийн 226 заалт, 2018 оны жилийн эцэст 162 шийдвэрийн 237 заалт/-*ээс буурсан, яамнаас хүргүүлсэн тайлангаас шийдвэр, заалтыг хяналтаас хасах талаар арга хэмжээ авч ажилласан байна.

2. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм батлах */Газрын тосны тухай хууль/,* уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам батлах */Хог хаягдлын тухай хууль/* заалтын хэрэгжилт удаашралтай байна.

3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх талаар яамны холбогдох нэгжүүд үр дүнтэй ажлууд хийж байгаа боловч хийсэн ажлынхаа биелэлтийг удаадаг */Газрын тосны хэлтэс, Хүнд үйлдвэрийн хэлтэс/,* ажлын гол үр дүнг товч тодорхой, баримт нотолгоотой биелэлт ирүүлдэггүй, өмнө гаргасан биелэлтээ шинэчилдэггүй, үр дүнг бус үйл явц тайлагнах байдал байсаар байна */бүх нэгжүүд/.*

4. Яамны эрхлэх асуудалд хамааралгүй буюу хэрэгжилт гаргахад хүндрэлтэй */Монгол баатарлаг туульсаа дээдлэн дэлгэрүүлэх тухай Ерөнхийлөгчийн 2019 оны 13 дугаар зарлиг/,* тухайн шийдвэр хүчингүй болсон */Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчингүй болсон/,* тухайн асуудал шүүхээр эцэслэн шийдэгдээгүй */Гацууртын орд/,* зэрэг 14 заалтад үнэлгээ өгөөгүй.

5. ЗГ-ын 2019.10.15-ны өдрийн 44 дүгээр тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн утга агуулгыг системд оруулаагүй, уг шийдвэрийг яаманд ирүүлээгүй тул биелэлтийг ерөнхий утгаар оруулав.

6. Гацууртын алтны үндсэн ордын асуудал шүүх байгууллагын түвшинд маргаантай, эцэслэн шийдвэр эцэслэн гараагүй байгаа тул энэ талаар батлагдсан тогтоол шийдвэрийн биелэлтэд үнэлгээ өгөөгүй болно.

7. Салбарт баримтлах бодлогын баримт бичгийг баталсан тогтоолын биелэлт гаргахад бэрхшээлтэй байна. “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлог”-ыг баталсан УИХ-ын 2015 оны 62 дугаар тогтоол, “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ыг баталсан ЗГ-ын 2018 оны 36 дугаар тогтоол, ЗГ-ын 2019 оны 317 тогтоолоор батлагдсан, “Алтны бичил уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй мөнгөн усны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр” нь өөрөө урт болон дунд хугацаанд хэрэгжих томоохон зорилтуудыг агуулж байх бөгөөд батлагдсан бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагаа нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр журмаар зохицуулагдаж байгааг анхаарч хяналтаас хасах нь зүйтэй байна.

8. Зэсийн баяжмал боловсруулах, нүүрснээс шингэн түлш үйлдвэрлэх, нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх төслүүдийн хэрэгжилт хангалтгүй, удаашралтай, бодит үр дүн гарахгүй байна.

9. Нэг удаагийн зохицуулалттай шийдвэрүүд хяналтаас хасагдахгүй байгааг анхаарах нь зүйтэй.

Тав. Санал, зөвлөмж.

1. Удаашралтай ажлуудыг эрчимжүүлэх, он удаан жил хэрэгжилт хангагдахгүй байгаа шийдвэр, заалтыг хүчингүй болгох, дараагийн шийдвэрийг гаргуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах.

2. Төрийн захиргааны удирдлагын газар хяналтанд авагдаж буй шийдвэрийг тухай бүрт нь хариуцах нэгж, албан хаагчийг эзэнжүүлэх.
3. “Эрдэнэс монгол” зэрэг салбарын төрийн өмчит компани, ТӨҮГ-уудаас холбогдолтой шийдвэрийн хэрэгжилтийг гаргуулж авах.
4. Холбогдох нэгжүүд ЗГХЭГ-т хүргүүлэх тайлангийн боловсруулалт, чанарт анхаарах, мэргэжилтний боловсруулсан тайлан, мэдээллийг харьяалах нэгжийн дарга нар хянаж ирүүлэх.
5. Дотоод нэгжүүд биелэлтийг тогтоосон хугацаанд гаргах, шинэчилж ирүүлж байх,
6. Холбогдох нэгжүүд дүгнэгдээгүй, удааширсан шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах шаардлагатай байна.
7. Хяналтаас хасуулах нийт 82 шийдвэрийн 109 заалтыг 2019 оны жилийн эцсийн тайлангийн хамт хүргүүлэх.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хийсэн үнэлгээний тайлан 57 хуудас.

Хянасан:
ХШҮДАГ-ын дарга

Г.Ганхүү

Үнэлгээ хийж тайлан, танилцуулга боловсруулсан:

Шинжээч

Б.Баяржаргал

Ахлах мэргэжилтэн

Д.Болортуяа

Мэргэжилтэн

Н.Цогтбаяр

Г.Батнайрамдал

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

2020.01.14